

САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны сарын
..... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дэх заалт, уг тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төсвийн байгууллагын нягтлан бодогчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн жилийн батлагдсан цалингийн санд багтаан нягтлан бодогч нарт нэмэгдэл олгохыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Б. ЖАВХЛАН

Х.БУЛГАНТУЯА

Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны дүгээр сарын -ны өдрийн дугаар тушаалын хавсралт

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН НЯГТЛАН БОДОГЧИД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. Төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлд хамаарах нягтлан бодогч нарт ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдөнө.

2. Нягтлан бодогчид ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана. Үүнд:

- 2.1.төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлт нь “Хангалттай” түвшинд үнэлэгдсэн байх;
- 2.2.ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх;
- 2.3.авлига албан тушаалын болон санхүүгийн зөрчилгүй байх;

3. Энэ шалгуур үзүүлэлтийн 2-т заасан нийтлэг шалгуурыг хангасан нягтлан бодогчийн ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1 Ерөнхий болон ахлах нягтлан бодогч

	Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
1	Мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжил	- дүн шинжилгээ хийх - асуудлыг шийдвэрлэх - үүрэг, хариуцлага хүлээх - мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдал	30
2	Программ хангамжийн ур чадвар	- компьютерын хэрэглээний болон санхүүгийн программд ажиллах - интернэт, сүлжээний орчинд ажиллах	20
3	Хувь хүний болон харилцааны ур чадвар	- асуудал болон баримт бичиг боловсруулах - өөрийгөө хөгжүүлэх - баримтыг эмх цэгцтэй, цагийг зүй зохистой ашиглах - бусдад зөвлөгөө өгөх, бусдыг сонсох	20
4	Зохион байгуулах, менежментийн ур чадвар	- хамт олноо манлайлан удирдан зохион байгуулах чадвар - эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх, - зөрчлийг зохицуулах,	10
5	Багаар ажиллах ур чадвар	- мэдлэг, мэдээллээ бусадтай хуваалцах - бусдын эрх мэдэл, бүрэн эрхийг хүндэтгэж, дэмжлэг үзүүлэх	20

3.2 Тооцооны нягтлан бодогч

	Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
1	Мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжил	- дүн шинжилгээ хийх - үүрэг, хариуцлага хүлээх - мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байдал,	30
2	Программ хангамжийн ур чадвар	- компьютерын хэрэглээний болон санхүүгийн программд ажиллах чадвар, - интернэт, сүлжээний орчинд ажиллаж чаддаг байх,	20
3	Хувь хүний болон харилцааны ур чадвар	- асуудал болон баримт бичиг боловсруулах, - өөрийгөө хөгжүүлэх, - баримтыг эмх цэгцтэй, цагийг зүй зохистой ашиглах, - бусдад зөвлөгөө өгөх, бусдыг сонсох,	30
4	Багаар ажиллах ур чадвар	- мэдлэг, мэдээллээ бусадтай хуваалцах, - бусдын эрх мэдэл, бүрэн эрхийг хүндэтгэж, дэмжлэг үзүүлэх,	20

4. Нягтлан бодогчийн ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.

5. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60,0 болон түүнээс дээш хувийг хангасан нягтлан бодогч нарт тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.

	Нийт үнэлгээ	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	86-100 оноо	21-25 хувь
2	76-85 оноо	16-20 хувь
3	61-75 оноо	11-15 хувь
4	60 оноо	10 хувь

6. Нягтлан бодогчийн ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр 3-аас доошгүй албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ.

7. Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

8. Ур чадварын нэмэгдлийг тухай нягтлан бодогчийн манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалзан олгохыг хориглоно.